


БАТЛАВ. ЭЛСЭЛТИЙН КОМИССЫН ДАРГА



Х.ЭНХЖАРГАЛ

## ШУТИС-ИЙН УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ

Ур чадварын шалгалт зохион байгуулах удирдамжийг “Бакалаврын хөтөлбөрт суралцагч элсүүлэх журам”-ын 6.3.2 заалтын дагуу 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн Элсэлтийн төв комиссын хурлын шийдвэрийг үндэслэн батлав.

Энэхүү удирдамж нь ШУТИС-ийн архитектур, дизайн чиглэлийн хөтөлбөрт элсэхийг хүсэгчидэд цахим ур чадварын шалгалт өгөх, чиглүүлэхэд оршино.

Ур чадварын шалгалтыг ШУТИС-ийн захирлын тушаалаар баталсан Ур чадварын шалгалтын комисс зохион байгуулна.

Ур чадварын шалгалтанд ШУТИС-ийн элсэлтийн бүртгэлд III бүлэгт бүртгүүлсэн Ерөнхий боловсролын 12-р ангийн төгсөгч, бүрэн дунд боловсролтой иргэн хамрагдана.

### Товчилсон нэр

Элсэлтийн комисс- ЭК

Ур чадварын шалгалтын комисс – УЧШК

Ур чадварын шалгалтыг дараах байдлаар зохион байгуулна.

### 1. Бүтээл, зурсан зураг

Элсэлтийн бүртгэлийн [www.elselt.edu.mn](http://www.elselt.edu.mn) веб хуудсанд бүртгүүлсэн сурагчдад имайл хаягаар нь Хар зургийн даалгавар, зураг зурах зөвлөмжийг илгээнэ. Элсэгчид нь илгээсэн даалгаврын дагуу зураг зурж материалыг А4 хэмжээтэй битүүмжилсэн дугтуйнд хийж ШУТИС-ийн УЧШК-т хүргүүлнэ. Зураг болон бүтээлийг А4 формат бүхий ватман цаасан дээр гүйцэтгэнэ. /Шуудангаар илгээх, өөрийн биеэр авчирч өгөх, итгэмжит хүнээр хүргүүлэх г.м/

### 2. Эссэ бичлэг

**Эссений агуулга:** нь өөрийн гаргасан бүтээлийн амжилтаас илүүтэйгээр өөрийн хүсэл тэмүүлэл, тухайн мэргэжлийг сонгох болсон шалтгааныг бичих бөгөөд өөрийн үзэл бодлоо хэрхэн илэрхийлсэн байдлыг нь дүгнэх болно.

**Эссений техникийн шаардлага:** Үгийн тоо 200-400, А4-н цаасан дээр бичсэн байна. Гараар гаргацтай бичиж болно, мөн Microsoft word дээр зураг бичлэг хавсаргалгүй, үсгийн шрифт Times new roman, бичиглэлийн хэмжээ Pt 12 байж болно.

### ЗӨВЛӨМЖ

#### Бүтээлийн танилцуулга

**Агуулга болон төрөл:** гар зураг, уран зураг, дижитал арт, сонирхсон мэргэжлийнхээ хүрээнд хийсэн бүх төрлийн бүтээлийн танилцуулга багтана. 5 минутаас илүүгүй видео бүтээл байж болно. Бүтээлийн танилцуулга нь тухайн

мэргэжлээр элсэхийг хүсэгчийн бүтээлч ур чадвар болон дүрслэн сэтгэх ур чадварыг дүгнэх зорилготой.

**Бүтээлийн техникийн үзүүлэлт:** Зургийн хэмжээ А4-н ватман цаасны хэмжээтэй, зургийн файлыг \*.JPG өргөртгөлтэйгөөр, видео файлыг \*.MP4 форматаар нийт 25GB-с илүүгүй хэмжээтэй дуу дүрсний чанарын шаардлага хангасан байхаар бэлдсэн байна.

## **САНАМЖ**

Хар зураг, эссэ бичлэг, бүтээлийг **Ур чадварын шалгалтын комисст хэмээн** хаяглаж битүүмжилсэн дугтуйнд хийн доорхи хаягаар ирүүлнэ. Дугтуйны зүүн дээд буланд **“овог, нэр, регистр, БҮТ-ийн бүртгэлийн дугаар, хаяг, холбоо барих утас”**- ны дугаарыг тус тус гаргацтай бичнэ үү.

Хичээлийн 1-р байранд битүүмжилсэн хайрцаг байрлуулна. Тус хайрцагт ур чадварын шалгалтын битүүмжилсэн дугтуйтай материалыг ажлын өдөр 10-18 цагийн хооронд хүлээж авна.

### **Бүтээл, Хар зураг, эссэ бичлэг хүлээн авах хаяг:**

Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, ШУТИС-ийн Хичээлийн 1-р байр, 1-217 тоот.

**Ш/х:** 46/250, **Утас:** 11-324319, 11-322126, 80848148, 11-324590-1021, 11-324590-2206,

**Э-шуудан:** [design2020@must.edu.mn](mailto:design2020@must.edu.mn)

**Хугацаа:** 2020.06.02-оос 2020.06.29-ны 18:00 цаг хүртэл.

## **ХУГАЦАА:**

Ур чадварын шалгалтыг 2020 оны 06-р сарын 02-ны өдрөөс 07 дугаар сарын 05-ны хооронд зохион байгуулна.

Элсэлтийн бүртгэл дуусах өдөр, цаг:	2020.07.07. 18:00 цагт
3-р бүлгийн бүртгэл хаах өдөр, цаг:	2020.07.05. 18:00 цагт
Зурсан зураг, эссэ, бүтээл хүлээн авах хугацаа:	2020.6.02-6.29-ийг хүртэл
Дүгнэх хугацаа:	2020.06.30-7.05-ны дотор

## **УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ ДҮГНЭХ**

Шалгалтын дүнг УЧШК дүгнэнэ. Ингэхдээ 200-800 хүртэл оноогоор дүгнэнэ.

Үүнд:

- Зурсан зураг, бүтээл - 600 оноо
- Эссэ бичлэг - 200 оноо

Элсэлтийн төв комисс. Улаанбаатар хот. 2020.05.27